


АГУУЛГА

НЭГ. 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	2
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	5
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	8
ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....	9
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	11
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	11
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ.....	12
НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	17
АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ.....	19
АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	21
ДҮГНЭЛТ	22
ХАВСРАЛТУУД	23


Уурхайн одоогийн байдал

1980-1982 онд Бэрхийн уурхайгаас Малийн ордын 2-р хүдрийн биетийн зүүн хойд гарш хэсэгт ил уурхайн олборлолт явуулж байсан бөгөөд ил уурхайн ухаш 10-59 м гүнтэй, 130 м өргөнтэй, 260 м урттай байна. Ил уурхайн ёроол +1243 м-ийн түвшинд байгаа ба ил уурхайн ёроолын өргөн 3-5 м өргөнтэй, траншейн налуу 3-4 градус байна. Тухайн жилүүдэд 58.0 мян.тн хүдэр олборлосон.



Зураг 2. Ил уурхайн одоогийн байдал

+1240 м, +1265 м түвшингүүдэд нэвтэрсэн хэвтээ малталтуудаас дээш орших блокуудад олборлолт явуулан нийт 63.6 мян.тн хүдэр олборлосон байна. +1265 м-ийн түвшний хэвтээ малталт нь 300 орчим м урттай ба ил уурхайн баруун хананы +1265 түвшин дэх аюулгүйн бермээс эхэлж нэвтэрсэн байна. Харин +1240 м-ийн түвшин дэх хэвтээ малталтыг ил уурхайн амнаас баруун урагш 45 м-ийн зайд +1259 түвшингээс налуу ам нэвтэрч +1240 м түвшинд хэвтээ малталт нэвтэрсэн байна. +1240 м-ийн түвшин дэх малталтын урт 500 м орчим байна.



Зураг 3. Уурхайд нэвтэрсэн хэвтээ малгалтууд

**ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөлт	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Нийт зардал, төг
Агаар орчин					
1	Уурхайн ажилчдын хотхоноос уурхайн налуу ам хүртэл уурхайн ажилчид машинтай зорчих үед тоосжилт үүсэх	Орчны тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайг шүүрлийн усаар услах.	Хуурайшилттай үед усалгаа хийсэн.	7-9 сард	265 000
2	Тээвэрлэлтийн үед тоос шороо босохоос сэргийлж мөн олон салаа зам гаргахаас сэргийлж замын тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахаас зайлсхийх,	Уурхайн талбайд шаардагатай 26ш замын тэмдэг тэмдэглэгээг хийж байршуулсан.	7-р сар	Үйл ажиллагааны зардалд орсон. /5 512 000/
Хөрсөн бүрхэвч					
3	Уурхайн эргэн тойрны тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихтэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох, талхлагдах, ургамлан нөмрөг устана.	Олон салаа зам гаргахаас сэргийлэх	Нийт ажилчдад байгаль орчны болон уурхайн замын хөдөлгөөний дүрэм журам сэдэвтэй сургалт хийгдсэн	7, 9-р сард	317 600

4	Уурхайн тэсэлгээнээс үүдэн газрын хэвлий эвдрэлд орох	Хөрснөөс дээж авч лабораторид шинжлүүлэх	Хэнтий аймгийн УЦУ, ОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораторт 4 цэгт 2 удаа шинжилгээ хийсэн.	7,9-р сард	317 600
Усан орчин					
5	Газрын доорх усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд уснаас дээж авч шинжлүүлэх	Хэнтий аймгийн УЦУ, ОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораторт 2 цэгт 2 удаа шинжилгээ хийсэн.	7, 9-р сард	221 000
Амьтны аймаг, ургамлан нөмрөг					
6	Олон хүний хөл хөдөлгөөн, машин техникийн холхилтоос ургамлан бүрхэвч талхагдана.	Тогтсон нэг маршрутаар ажилчдыг зорчуулах, ан амьтан агнахгүй байх	Байгаль орчны үйл ажиллагаа, байгаль орчны зөрчил, зөрчлийг мэдээлэх, арилгах гэсэн сэдвийн хүрээнд нийт ажилчдад тогтмол сургалт ордог.	тогтмол	1 000 000



Зураг4. Замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг5. Байгаль орчны сургалт

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Малийн далд уурхайн төслийн үйл ажиллагаа нь 13 жил хэрэгжих бөгөөд ашиглалтын үе шатуудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төслийн ТЭЗҮ, БОННУ-ний тайланд тусгасан. Иймд 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн төлөвлөгөө тусгагдаагүй болно.

2023 онд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд уурхайн бүсэд 500 ширхэг улиас мод суулгасан байна.



Зураг 6. Уурхайн бүсэд мод тарьсан байдал

ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Сум орон нутгийн төр захиргааны байгууллагын мэргэжилтнүүд, удирдлагуудтай зөвшилцөж 2023 онд Батноров сумын 3-р багийн “Цог-Өндөр” нэртэй газарт уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон карьерт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр тохиролцсон.

Тус талбай нь том жижиг нийлсэн 5 хэсгээс бүрдэх бөгөөд талбайн хэмжээ 1.1га, эзлэхүүн 47.23мян.м3, гүн нь 2м-ээс 20.2м хүртэл гүнтэй байна. 2023 онд 0.26га талбайд ил задгай хаягдсан хог хаягдал, малын сэг зэмийг бушилж дарсан бөгөөд нийт 6500м3 техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.



Зураг 7. Карьерын харагдах байдал



Зураг 8. Нөхөн сэргээлтийн ажил

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ашигт малтмалын тухай хуулийн 41-р зүйлийн 41,1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан.

Хуулийн дээрх зүйл заалтын дагуу “Мальфлюорит” ХХК-ийн Малийн уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай болон нөлөөллийн бүст газар эзэмших эрхийн гэрчилгээтэй айл өрх байхгүй байна. Иймд 2023 онд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сард Археологи, Палеонтологийн судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн бөгөөд судалгааны ажлын тайлангийн үр дүнгээр түүх, соёлын ямар нэгэн олдвор, дурсгал илрээгүй.

ДОЛОО. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал, төг	Тайлбар
1	Аянга цахилгаан. Аянга буух, улмаар гал түймэр гарах, түлш, шатах тослох материал тэсэрч дэлбэрэх явдал юм.	Аянга зайлуулагчийг цахилгааны байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах, Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх.	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	1 000 000	Уурхайн барилга байгууламж баригдах үед зураг төслийн дагуу суурилуулсан
2	Аадар бороо: Дэд бүтцийн байгууламж нурж сүйдэх, уурхай үерлэх, дэд бүтцийн байгууламж эвдэрч сүйдэх, цахилгаан тасрах зэрэг эрсдэлтэй.	Хур бороо, үер уснаас хамгаалах суваг, шуудуу татах,	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	1 500 000	Уурхай болон кэмпэд үерийн ус орж болзошгүй хэсэгт хамгаалалтын шуудуу татсан
3	Шороон шуурга. Үзэгдэх орчин хязгаарлдагдсанаар аваар, осол гарах нөхцөл бүрдэнэ. Хүчтэй шороон шуурга салхи нь ажилчидын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлнө.	Замын арчилгаа тордолгоог тогтмол хийх.	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	Тогтсон чиглэл маршрутаар зорчих, БО-ны чиглэлээр нийт ажилчдад тогтмол сургалт ордог.
4	Халдварт өвчин. Төсөл хэрэгжиж буй бүс нутагт тахал олон нийтийг хамарсан тахал, халдварт өвчин гарснаар хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулна, хөдөлмөрийн чадвар түр хугацаанд алдах эрсдэлтэй.	Уурхайн ажилчдад хангалттай хүрэхүйц нэг удаагийн бээлий, ариутгалын хэрэгслийг бүрдүүлэх.	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	500 000	Цар тахал, халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор нэг удаагийн хамгаалах хэрэгслийг ажилчдад тогтмол олгож байсан
5	Гал түймэр. Нефтийн бүтээгдэхүүний асгаралтын улмаас хөрсний бохирдол үүсгэх, хүний санамсар болгоомжгүй байдлаас үүдэн гал түймэр гарах	Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдалд нэгж тус бүрийн удирдах ажилтан өдөр бүр тогтмол хяналт тавьж илэрсэн дутагдлыг биечлэн засах, холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	1 000 000	Уурхайд байрлуулсан гал унтраах багаж хэрэгсэлд тогтмол үзлэг шалгалт хийдэг. Нэмэлтээр 38 галын хор авсан
	Нийт зардал			4 000 000	



Зураг 9. Уурхайн ШТС-д газардуулга, аянга зайлуулагч хийсэн байдал



Зураг 10. Уурхайн амны үер, уснаас хамгаалсан шуудуу



Зураг 11. Объектод галын булан, галын хор байрлаалсан байдал



Зураг 12. Нэг удаагийн хамгаалах хэрэгсэл болон ариутгал хийж буй байдал

**НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Арга хэмжээ	Зардал,төг	Тайлбар
1	Ахуйн	Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна.	450 000	Ажилчдын гэрийн гадна, постонд ангилан ялгалттай сав хогийн байршуулсан. Хогийг түр хогийн цэгт хадгалж сумын төвлөрсөн хогийн цэгт хаядаг.
		Хог хаягдлын төлбөрөө төлнө	800 000	Хог хаягдлын төлбөр төлсөн
2	Үйлдвэрийн хог хаягдал	Уурхайд ашиглаж буй машинаас гарсан дугуйг зориулалтын талбайд хуримтлуулах	-	Одоогоор хуримтлал үүсээгүй.
3	Аюултай хог хаягдал	Машинаас гарсан хаягдал, тос масло болон бусад аюултай бодисуудыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий компанид нийлүүлэх	1 000 000	Одоогоор ашигласан тос маслыг зориулалтын талбайд хадгалж байна. Зөөвөрлөн нийлүүлэх хэмжээний хуримтлал үүсээгүй.
Нийт зардал			2 250 000	




Зураг 13. Ангилан ялгалттай хогийн



Зураг 14. Нийтийн цэвэрлэгээ



Зураг 15. Түр хогийн цэг, ажилласан тос масло хураах талбай



Зураг 16. Дугуй болон хог хаягдлыг зориулалтын талбайд буулгасан байдал

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тус онд Хэнтий аймгийн УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лаборатортой гэрээ байгуулан 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хамтран ажиллаж байна.

2023 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаа төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Шинжилгээний үр дүнг үндэслэн Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын Улсын байцаагчийн 2023 оны 10-р сарын 20-ний өдрийн 22-06-020/134 тоот “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээ хэмжээ” MNS5850:2019 стандарт, “Агаарын чанарын стандарт” MNS4585:2016, “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS0900:2018 стандартын шаардлага хангаж байна гэсэн дүгнэлт гарсан байна.

Лабораторын шинжилгээний үр дүн, шинжилгээний дүгнэлтийг хавсралтаар оруулав.

Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийсэн хугацаа	Давтамжийн тоо	Нийт зардал, төг
Агаар					
1	Тоос нийт (PM10, PM2.5), CO ₂ , NO ₂ , SO ₂ , H ₂ S	Далд уурхайн агааржуулалтын амны хэсгээс-1 цэг Далд уурхай дотор-1 цэг	7, 9 сард	2 удаа	530 000
Хөрс					
2	Агрохими болон хүнд металлийн шинжилгээ	Уурхайн ажилчдын кемп Хог хаягдлын цэг орчим Ажилдчын жорлон Тэсэлгээний агуулахын ойр орчим	7, 9 сард	2 удаа	635 200
Усан орчин					
3	Бактериологи Химийн ерөнхий шинжилгээ	Унд ахуйн ус Шүүрлийн ус Хаягдал ус	7, 9 сард	2 удаа	442 000
	Нийт	Нийт зардалд томилолтын зардалд, шатахууны зардал орсон болно.			1 607 200



Зураг 17. Орчны хяналт шинжилгээний дээжлэлт, хэмжилт


**АРАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

Хүснэгт 6. Удирдалга зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	Хугацаа	Зардал, төг
1	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.	Сум орон нутгийн удирдлагууд болон мэргэжилтнүүд уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь ирж танилцсан.	9 сард	400 000
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	Жил, улирал, сар, 7 хоногоор ХАБЭА болон БО чиглэлээр сургалтын хуваарь гаргаж гамшгаас хамгаалах, аваар устгах төлөвлөгөө, мөн уурхайн үйл ажиллагаанд мөрдөгддөг дүрэм журмуудыг ажилчдад таниулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг.	тогтмол	600 000
3	2023 онд байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон Хэнтий аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлайнг хуулийн хугацаанд хүргүүлсэн.	2023 оны 11-р сарын 01	450 000
	Нийт			1 450 000

**АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД
ТАЙЛАГНАХ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн малчин иргэд, сум багийн иргэд, сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд танилцуулсан.



Зураг 18. БОМТ-ний хэрэгжилтийн танилцуулга

**АРВАН ХОЁР. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
биелэлтийн нийт зардал**

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал. төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2 121 200
2	Дүйцүүлэн хамгаалах ажил	4 000 000
3	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	4 000 000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	2 250 000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1 607 200
6	Удирдлага зохион байгуулалт	1 450 000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	2 000 000
	Нийт	17 428 400

ДҮГНЭЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын ажил нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгах, бууруулах, арилгах арга хэмжээ авч ажиллалаа.

2023 онд “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд уурхайн бүсэд 500 ширхэг улиас мод суулгасан бөгөөд цаашид модны тоо, нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Мөн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд сум орон нутгийн төр захиргааны байгууллагын мэргэжилтнүүд, удирдлагуудтай зөвшилцөж Батноров сумын 3-р багийн “Цог-Өндөр” нэртэй газарт уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон том хэмжээний карьерийн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлэн 3-5 жилийн хугацаанд бүрэн дуусгаж сум орон нутагтаа хүлээлгэн өгөх зорилт тавин ажиллаж байна.

Хавсралт материалууд

- 1. ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ*
- 2. БОХ-3 маягт*
- 3. ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал*
- 4. БХМТ-ний барьцаа хөрөнгө байршуулсан баримт*
- 5. Хог хаягдлын гэрээ*
- 6. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт*
- 7. Хэнтий аймгийн УЦУОШТ-тэй байгуулсан гэрээ*
- 8. Лабораторын шинжилгээний үр дүн*
- 9. Шинжилгээний дүгнэлт*